



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ  
ДАРГА НАРТ

**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,  
Утас: 26-24-80, Факс: 263727  
И-мэйл: info@mes.gov.mn, Веб сайт: www.mes.gov.mn

2021. 07. 08 № 1а/3511

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Их хурлаас 2019 онд батлагдсан Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн дагуу 2021-2022 оны хичээлийн жилд бага ангийн суралцагчдыг үдийн хоолны үйлчилгээнд хамруулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр тулгамдаж буй асуудлыг Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо болон Монгол Улсын Засгийн газарт танилцуулга хийж, тогтоол тэмдэглэл батлагдсан.

Дээрх тогтоол, тэмдэглэлд тусгагдсан ажлуудыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж ажиллах чиглэлийг хүргүүлж байна. Үүнд:

1. Ерөнхий боловсролын сургуульд стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байрыг бий болгох, зориулалтын тоног төхөөрөмжөөр хангах, төсөв санхүүжилтийг шийдвэрлэх, олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
2. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах мэргэжлийн хүний нөөцийн бүтэц, орон тоог батлах, төсвийг шийдвэрлэх, мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулах;
3. Үдийн хоолны норматив зардалд хяналт тавих, орон нутгийн онцлогт тохирсон тогтвортой, хүртээмжтэй хүнсний хангамжийн тогтолцоог бүрдүүлэх, худалдан авалтыг оновчтой хэлбэрээр зохион байгуулах;
4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт эрүүл хооллолт, хоол шим тэжээлийн боловсрол олгох, түгээх ажлыг эрчимжүүлэх, эцэг эх, олон нийт, иргэдийг татан оролцуулах, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.

Мөн Боловсрол шинжлэх ухааны сайд болон аймаг, нийслэлийн Зацаг дарга нарын хооронд 2021 онд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын хүүхдийн хоол хүнсний хангамж, үйлчилгээний чиглэлээр тусгагдсан ажлуудыг шуурхай зохион байгуулж ажиллах шаардлага үүсч байна.

14216 2164

Иймд дээрх тогтоол, тэмдэглэл, гэрээнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлж, үр дүнг хавсралт хүснэгтийн дагуу гарган 2021 оны 08 дугаар сарын 01-ний дотор албан бичгээр ирүүлнэ үү.

Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны 36 дугаар тэмдэглэлийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт. 5 хуудастай.

Хувийг: Аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газарт



Л. ЭНХ-АМГАЛАН

## ТОГТООЛ, ТЭМДЭГЛЭЛ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

	АРГА ХЭМЖЭЭ	ХЭРЭГЖИЛТ	ШИЙДВЭР	ҮР ДҮН
Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2021 оны 05 дугаар тогтоол				
1.	Заалт.....			
Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 36 дугаар тэмдэглэл				
2.	Заалт.....			
Боловсрол шинжлэх ухааны сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээ				
3.	Заалт			

----oo0oo---



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ

2021 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**Ерөнхий боловсролын сургуулийн  
хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай  
хуулийн хэрэгжилтийг хангах зарим  
арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсэг, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль болон "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2019 оны 53 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж, холбогдох байгууллагын үйл ажиллагаатай танилцсан Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай:

**2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн бага ангийн суралцагчдыг өдрийн хоолны үйлчилгээнд хамруулах хүрээнд:**

1/сургуулийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг хүн амын зохистой хооллолтын талаарх зөвлөмжид заасан хэмжээ, инфляцийн түвшинтэй уялдуулан шинэчлэн баталж, 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх;

2/ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрыг стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн шинээр барих, засварлах, өргөтгөх болон стандартын шаардлага хангасан зориулалтын тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах зардлыг шийдвэрлэх;

3/нийслэл болон орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн нутгийн захиргааны байгууллагад сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хариуцсан орон тоог бий болгож, цалин хөлсний асуудлыг шийдвэрлэх;

4/мэргэжлийн хүний нөөц /хоол зүйч, тогооч/-ийг бэлтгэх, чадавхжуулах болон мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх, тэдгээрийн цалин хөлс, нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх асуудлаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулж, холбогдох хууль, тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5/энэ тогтоолын 1.1, 1.2, 1.3, 1.4 дэх дэд заалтад заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөвт нэмж шаардагдаж байгаа зардлыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 онд батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар шийдвэрлэх;

**Хууль, тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд:**

6/Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 18 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулиудыг үдийн хоол үйлдвэрлэлд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөө"-г хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, санхүүжилтийн эх үүсвэрийг 2022 оны Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган батлуулах;

7/төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн хоол үйлдвэрлэлийн зориулалт бүхий талбайг бусдад ашиглуулсан төлбөрөөс төвлөрүүлэх орлогыг 100 хувь тухайн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрны засвар, тоног төхөөрөмжид зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах;

8/багш, ажилчид, эцэг, эх, асран хамгаалагчийн хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг өргөжүүлэх талаар арга хэмжээний санал боловсруулж, хэрэгжүүлэх;

9/ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд мэргэжлийн хяналтын байгууллагаар үнэлгээ хийлгэж, санал дүгнэлтийг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, цаашид үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах;

10/орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, аюулгүй хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох, сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний дагуу зохион байгуулах ажлыг эхлүүлэх;

11/2022 оноос эхлэн хуулийн хэрэгжилтэд шаардагдах урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсөвт бүрэн тусгах, аж, ахуйн нэгж, байгууллагын хандив, олон улсын байгууллага, гадаад орнуудын буцалтгүй тусламжийн хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх.

2.Энэ тогтоолын хэрэгжилтийн тайланг Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд 2021 оны 8 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын хэсэг /П.Анужин/-т даалгасугай.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Г.ДАМДИННЯМ

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны 36 дугаар тэмдэглэлд:

“ХII.11. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:

1. Нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг шинэчлэн тогтоох, нийслэл болон орон нутгийн боловсролын асуудал хариуцсан захиргааны байгууллагад сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий хоолзүйч ажиллуулах асуудлыг төсвийн шинэчлэлтэй уялдуулан хамтран судалж, саналаа Засгийн газарт танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт;

2. Сургуулийн хоол үйлдвэрлэлийн ажилчдын ажлын онцлог нөхцөл, ачаалалд тохируулан албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн шатлалтыг тогтоох асуудлыг судлан танилцуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт;

3. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрлэлийг дэмжих замаар тухайн орон нутгаас нийлүүлэх болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнээр үйлчлэх боломжийг судалж, шийдвэрлэх чиглэлээр аймаг, нийслэлийн Засаг дарга нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд;

4. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандарт, шаардлага хангасан зориулалтын байргүй сургуульд шинээр зориулалтын байр барих ажлын зураг төслийг 2021 онд багтаан боловсруулж, 2022 оноос улсын төсөвт тусгуулах, төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн хоол үйлдвэрлэлийн зориулалт бүхий талбайг бусдад ашиглуулсны төлбөрөөс төвлөрүүлэх орлогыг 100 хувь тухайн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрны засвар, тоног төхөөрөмжид зарцуулах боломжийг судлан танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;

5. Боловсролын салбарын хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үнэлгээ хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлж, хяналт шалгалтыг эрчимжүүлэх, сургуулийн хоол

үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг ерөнхий гэрээгээр худалдан авах боломжийг судлан үзэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР